Улаанбаатар хотын залуу иргэдийн дундах утаат тамхины хэрэглээ, тамхины донтолтод нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлэх нь

С.Халиун[1], Б.Эгшиглэн[1], Э.Номин-Эрдэнэ[2],Б.Алтанхишиг[2], Н.Марал[2], Ф.Екатерина[2], З.Мандуул[1], Г.Доржбалам[3], Ө.Жаргалтулга[1,3], Э.Ренчиндорж[3], О.Чимэдсүрэн[4]

[1]Анагаах Ухааны Сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
[2]Био-Анагаахын Сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
[3]Нотолгоонд суурилсан анагаах ухааны судалгааны институт
[4] Ерөнхийлөгчийн тамгын газар
Цахим шуудан:Jargaltulga.U@gmail.com, Утас:+976 85300909

Түлхүүр үг:
Тамхидалт
Донтолт
никотин
хамааралт
байдал
Залуусын
эрүүл мэнд

Товч утга:

Үндэслэл:
Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд залуу иргэдийн дундах тамхидалт нэмэгдэж байгаа нь утаат тамхины үйлдвэрлэл, хэрэглээ ихэссэнтэй шууд холбоотой бөгөөд үүнийг дагаад никотинд донтох тохиолдлууд эрс нэмэгдэж байгаа билээ. **Зорилго:** Тиймээс бид энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын залуу иргэдийн дундах утаат тамхинд донтох донтолтын зэргийг үнэлж, түүнд нөлөөлж болох хүчин зүйлсийг харьцуулан судлахыг зорилоо. **Арга, аргачлал:** Улаанбаатар хотын 13-44 насны хүмүүсээс агшингийн судалгааны аргаар 2023 оны 11-р сараас 2024 оны 1-р сар хүртэл судалгааг явуулсан ба түүврийг санамсаргүй аргаар цуглуулсан. Асуумжид “STEPS”, болон “GYTS”-ийг тус тус ашигласан. Үр дүнгийн боловсруулалтад IBM-SPSS 26 программ дахь ерөнхий дескриптив болон Хи-кватрат аргуудыг ашиглаж, $p<0.05$ үед статистик ач холбогдол бүхий ялгаатай гэж үнэлсэн. **Үр дүн:** Судалгаанд нийт 1362 хүн оролцсоноос 59.5% (n=811) эмэгтэй, 40.5% (n=551) эрэгтэй, дундаж нас 21.5±7.9 байв. Нийт судалгаанд хамрагдагсдын 18.8% нь янжуур тамхи, 23.2% нь электрон тамхи татаж байгаа ба тамхины нийт хэрэглээ 34.9%-ийн үзүүлэлттэй байсан. Хүйсээр харьцуулахад аль ч тамхины хэрэглээ эрчүүдийн дунд илүү байсан ба янжуур тамхи болон нийт тамхины хэрэглээ 25-44 насныхны дунд, харин электрон тамхины хэрэглээ 16-24 насныхны дунд хамгийн их байна. Тамхи хэрэглэдэг хүмүүсийн 43.1% нь гэртээ тамхи татдаг хүнтэй, 72.9% нь ажил дээрээ тамхи татдаг хүнтэй байсан. Сүүлийн 1 жилийн хугацаанд ямар нэгэн тамхины хор уршгийн талаар ярилцаж байсан хүмүүсийн 27.3% ($p<0.05$) нь тамхи татаж байна. Харин анх хэдэн насанд тамхи сорж үзсэн болон ямар төрлийн тамхи сорж үзсэн байдал нь тамхины хэрэглээтэй хамааралгүй гарсан. Никотинд хамааралт байдлын хувьд тамхи татдаг хүмүүсийн 16.4% (50) нь сонирхон хэрэглэгч, завсрын хэрэглэгч 34.2% (104), бэхжсэн хэрэглэгч 49.3% (150) байгаа ба бэхжсэн хэрэглээ нь янжуур тамхи хэрэглэгчдийн дунд өндөр байна. Тамхи хэрэглэгчдийн донтолтонд тамхи үйлдвэрлэгч борлуулагч үнэгүй тамхи санал болгох (53.3 $p<0.0001$), олон нийтийн газар (37.8% $p<0.0001$) болон гэрийн нөхцөлд (37.2% $p<0.0001$) дам тамхидалтанд өртөх нь бэхжсэн хэрэглэгч болоход хамгийн ихээр нөлөөлж байна. **Дүгнэлт:** Улаанбаатар хотын залуучуудын 3 хүн тутмын 1 нь ямар нэгэн төрлийн тамхийг хэрэглэж байна. Тамхины хэрэглээг бууруулахад сургууль, байгууллагуудын иргэдийн дундах эрүүл мэндийн боловсролыг дэмжих болоод ямар ч төрлийн тамхины ил болон далд сурталчилгааг зогсоож, хяналт тавих шаардлагатай.

Үндэслэл: Дэлхий дээрх нийт 1.3 тэрбум тамхи хэрэглэгчдийн 80 орчим хувь нь тамхинаас үүдэлтэй өвчлөл, нас баралтын тохиолдлыг эзэлж байна[1]. Эдгээр нас баралтын дийлэнх нь бага, дунд орлогтой орнуудад зонхилон тохиолддог ба дундаж орлогтой орны нэг болох Монгол улсын тамхины хэрэглээ өндөр байгаа нь хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан юм[2]. Монгол улсын хэмжээнд 2019 оны байдлаар

“Халдварт бус өвчний тархалт, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийн үндэсний судалгаа”-нд 4 хүн тутмын 1 нь тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дундах халдварт бус өвчний эрсдэлийн гол шалтгаануудын нэг болж байна[3]. Сүүлийн жилүүдэд залуу иргэдийн дундах тамхидалт нэмэгдэж байгаа нь утаат тамхины үйлдвэрлэл, хэрэглээ ихэссэнтэй холбоотой бөгөөд үүнийг дагаад никотинд донтох тохиолдлууд эрс нэмэгдэж байгаа билээ.

Тамхины гол донтуулагч найрлага бол никотин юм. Тамхины утаагаар амьсгалахад тархинд 7-30 секундын дотор дунджаар 1 мг никотиныг хүргэгддэг бөгөөд энэ нь тархинд допамин ялгаруулагч никотины рецепторуудыг идэвхжүүлдэг.1 Никотины өндөр концентраци нь тархинд хурдан хүргэх нь хамгийн том донтуулах шалтгаан болгодог байна.

Тамхины хэрэглээнээс үүдэлтэй донтолт нь халдварт бус өвчинөөр өвдөх эрсдэлийн томоохон шалтгаан болж байгаа учраас бид энэхүү судалгаагаар Улаанбаатар хотын залуу иргэдийн дундах утаат тамхинд донтох донтолтын зэргийг үнэлж, түүнд нөлөөлж болох хүчин зүйлсийг насны бүлэг, тархалтаар нь харьцуулан судлахыг зорилоо.

Зорилго: Улаанбаатар хотын залуу иргэдийн дунд тамхины хэрэглээний тархалт болон эдгээрт донтоход нөлөөлж болох зарим хүчин зүйлсийг үнэлэх

Зорилт:

I. Улаанбаатар хотын залуу иргэдийн дундах тамхины хэрэглээний тархалтыг тодорхойлох

II. Тамхины хэрэглээтэй холбоотой хамааралт хүчин зүйлийг судлах

III. Никотины донтолтод нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах

Арга, аргачлал: Уг судалгааг агшингийн судалгааны аналитик загварыг ашиглан 2023 оны 11 сараас 2024 оны 1 сар хооронд Улаанбаатарын 13-44 насны хүн амын дунд явуулсан. Өмнө нь 2014 болон 2019 онд ДЭМБ-с Монгол улсад хэрэгжсэн “Дэлхийн Залуусын Тамхины Судалгаа GYTS”-нд 13-15 насныхныг,4 2005 оноос хойш 5 жил тутам үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулагддаг “ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа STEPS”-нд 15-64 насныхныг[5] хамруулж байсан бөгөөд үүнээс үндэслэн уг судалгаанд хамруулах насны бүлгийг 13-44 нас болгон сонгосон. Бүлэг хооронд ялгааг тодорхойлоход чанарын хувьсагчдыг Хи-квадратын тестийг ашиглан $p<0.05$ үед статистик ач холбогдол бүхий ялгаатай гэж үзсэн. Статистик боловсруулалтыг IBM Statistical Package for the Social Sciences 26.0 ашиглан гүйцэтгэв.

Үр дүн: Нийт судалгаанд хамрагдагсдын тамхины хэрэглээний хувьд 18.8% нь янжуур тамхи, 23.2% нь электрон тамхи, эсэргээрээ усан тамхи 2.1%, навчин тамхи 1.7%, гаанс 0.1% зэрэг тамхины хэрэглээ хамгийн бага үзүүлэлттэй татаж байгаа ба тамхины нийт хэрэглээ 34.9%-ийн үзүүлэлттэй байсан.

Хүйсээр харьцуулан үзэхэд эрчүүдийн 48.1% ямар нэг тамхины хэрэглээтэй, эмэгтэйчүүдийн 25.6% нь тамхины хэрэглээтэй буюу аль ч тамхины хэрэглээ эрчүүдийн дунд илүү байна. Тамхины хэрэглээг насны бүлэгтэй харьцуулан судлахад янжуур тамхи болон нийт тамхины хэрэглээ 25-44 насныхны дунд, харин электрон тамхины хэрэглээ 16-24 насныхны дунд хамгийн их байна.


Хүснэгт 1. Нийт судалгаанд хамрагдагсдын ерөнхий мэдээлэл

		N	%
Хүйс			
	Эр	551	40.5%
	Эм	811	59.5%
Насны бүлэг			
	13-15	306	22.5%
	16-24	688	50.5%
	25-44	368	27.0%
Ам бүл			
	1	27	2.0%
	2-3	275	20.2%
	4-5	699	51.4%
	6-с дээш	359	26.4%
Дүүрэг			
	Баянгол	157	11.5%
	Баянзүрх	370	27.2%
	Хан-уул	136	10.0%
	Чингэлтэй	45	3.3%
	Сүхбаатар	83	6.1%
	Сонгино-хайрхан	164	12.0%
	Багануур	407	29.9%
Ажлын хэлбэр			
	Ажил хийдэггүй	235	31.5%
	Цагийн ажил	120	16.1%
	Гэрээт ажил	38	5.1%
	Төрийн байгууллага	165	22.1%
	Төрийн бус байгууллага	36	4.8%
	Хувиараа бизнесс эрхлэгч	39	5.2%
	Хувийн байгууллага	114	15.3%



Зураг 1. Тамхины хэрэглээ, төрлүүдээр

Нийт тамхины хэрэглээг Улаанбааатар хотын дүүргүүдийн тархалтыг тодорхойлоход төвийн дүүргүүдийн тамхидалтын тархалт ойролцоо буюу үүнээс хамгийн өндөр нь Хан-Уул дүүрэг 52.9% харин Багануур дүүрэгт тамхидалтын тархалт төвийн дүүргүүдтэй харьцуулахад бага буюу 10.3% байна.



Зураг 2. Улаанбаатар хотын дүүргүүдийн тамхидалтын тархалтыг тодорхойлсон нь.

Тамхидалтанд нөлөөлж буй хүчин зүйлсийг

уялдуулан судлахад тамхи хэрэглэдэг хүмүүсийн 43.1% нь гэртээ тамхи татдаг хүнтэй, 72.9% нь ажил дээрээ тамхи татдаг хүнтэй байсан. Сүүлийн 1 жилийн хугацаанд ямар нэгэн тамхины хор уршгийн талаар ярилцаж байсан хүмүүсийн 27.3% ($p<0.05$) нь тамхи татаж байна. Харин анх хэдэн насанд тамхи сорж үзсэн болон ямар төрлийн тамхи сорж үзсэн байдал нь тамхины хэрэглээтэй хамааралгүй байна. Янжуур болон электрон тамхинд донтоход нөлөөлж буй хүчин зүйлсийг судлахад тамхины хор уршгийн талаар ярилцахгүй байх ($p<0.05$), тамхины хямдрал, сурталчилгаа харах ($p<0.05$), тамхи борлуулагч, үйлдвэрлэгчээс үнэгүй тамхи санал болгох ($p<0.001$), олон нийтийн газар $p<0.001$) болон гэртээ ($p<0.001$) дам тамхидалтад өртөх хүчин зүйлс нь нөлөөлж байна.

Никотин хамааралт байдал электрон болон янжуур тамхинд донтолт үүсгэж буй байдлаар Бэхжсэн хэрэглэгч, Завсрын хэрэглэгч, Сонирхон хэрэглэгч хэмээн 3 бүлэг болгон үзэж бэхжсэн хэрэглэгч тохиолдолд никотин хамаарал өндөр буюу тамхины донтолт их, завсрын болон сонирхон хэрэглэгч үед никотины хамаарлын хэмжээ дунд болон бага гэж үзсэн.

Тамхи татдаг хүмүүсийн 16.4% (50) нь сонирхон хэрэглэгч, завсрын хэрэглэгч 34.2% (104), бэхжсэн хэрэглэгч 49.3% (150) байна. Харин никотин хамааралт байдлыг тамхины төрөлтэй уялдуулан шинжлэхэд янжуур тамхи хэрэглэгчид нь бэхжсэн хэрэглэгч болох нь электрон тамхи хэрэглэгчдээс илүү, нөгөө талаараа бүх төрлийн электрон цахилгаан тамхи хэрэглэгчид завсрын хэрэглэгч болох тооцоолол янжуур тамхи хэрэглэгчдээс өндөр байна.

Тамхи хэрэглэгчдийн донтолтонд тамхи үйлдвэрлэгч борлуулагч үнэгүй тамхи санал болгох (53.3 $p<0.0001$), олон нийтийн газар (37.8% $p<0.0001$) болон гэрийн нөхцөлд (37.2% $p<0.0001$) дам тамхидалтанд өртөх нь бэхжсэн хэрэглэгч болоход хамгийн ихээр нөлөөлж байна.

Хэлцэмж: Энэхүү судалгааны хувьд юун түрүүнд Улаанбаатар хотын залуу иргэдийн дундах тамхины хэрэглээний тархалтын хувийг дүгнэсэн бөгөөд нийт судалгаанд оролцогсдын 34.9% нь ямар нэгэн тамхины хэрэглээтэй байсан нь STEPS-2019 судалгааны үр дүнтэй харьцуулахад даруй 10.7 хувиар өссөн үзүүлэлт ажиглагдсан.6 Хүйсийн хувьд авч үзэхэд эрчүүдийн тамхины хэрэглээ 2019 оны үеэс 4.4% өсөж 48.1%-ийн үзүүлэлттэй гарсан бол эмэгтэйчүүдийнх 2019 онд 5.0%-тай байснаа 25.6%-тай болж, 20.6%-иар огцом нэмэгджээ. Эрчүүдийн дундах тамхины хэрэглээ эмэгтэйчүүдийнхээс их буюу никотинд хамааралтай болох эрсдэл 3-5 дахин их байсан нь өмнөх онуудтай харьцуулахад адил хэмжээнд байна.

Энэхүү тоон үзүүлэлтүүдийг дэлхий дахины нийт тамхины хэрэглээтэй жишин үзвэл, ДЭМБ-ын тайлан үзүүлэлтийн 2019 оны байдлаар 1.14 тэрбум хүн буюу дэлхийн нийт хүн амын 14.8% нь тамхи хэрэглэдэг гэсэн үзүүлэлттэй байснаа 2024 онд 1.25 тэрбум буюу 15.4% болж, 0.6 хувиар нэмэгдсэн нь манай улсын дийлэнх хүн амыг эзэлдэг Улаанбаатар хотын тамхины хэрэглээ дэлхийн дундаж үзүүлэлтээс 19.4%-иар илүү байгааг харуулж байна.[7]

Нийт тамхи хэрэглэгсдийн насны ангиллын хувьд хамгийн их тамхи татдаг бүлгийг 25-44 насныхан 54.0 хувьтайгаар эзэлж байгаа бөгөөд 2023 онд дэлхий дахины тамхины хэрэглээ 35-44 насныханд илүү их тохиолдож байсан нь манай судалгааны үр дүнтэй адил үзүүлэлттэй байна.[8]

Үүнээс, электрон тамхийг илүү залуу хүмүүс буюу 16-24 насныхан 64.1%-тай хэрэглэж байгаа бөгөөд уг насны бүлэг янжуур тамхийг хамгийн бага хувьтайгаар (3.5%) хэрэглэж байна. Залуу насныхан электрон тамхийг ихээр хэрэглэж эхэлсэн нь уг тамхинд тавих хяналт шаардлага янжуур тамхитай харьцуулахад бага, бага насны болон насанд хүрээгүй хүүхдүүд худалдан авч хэрэглэхэд илүү амар байдаг гэх мэт хууль эрхзүйн зүгээс хамаарч байж болзошгүй нь харагдаж байгаа тул залуу иргэдийн дундах электрон тамхины хэрэглээг нарийвчлан судалж, энэ талаас хууль эрхзүйн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн болон өсвөр үеийн дундах тамхины хэрэглээ өсөж байгаа нь электрон тамхины хэрэглээ өсөж байгаатай холбоотойг электрон тамхины хэрэглээ эдгээр бүлгүүдэд хамгийн ихээр нэмэгдэж байгаа үзүүлэлт батлан харуулж байгаа бөгөөд электрон тамхины хор уршгийн талаар бүрэн тайлбарласан судалгаа хараахан батлагдаагүйгээс эдгээр бүлгийн хүмүүс “янжуур тамхинаас хор уршиг багатай” гэх ойлголттой байдаг тул уг тамхины хэрэглээ хяналтгүй өсөх болсон байна.[9]

Газарзүйн байршлын хувьд үзэхэд, дэлхийн улс орнуудын хувьд залуучуудын дундах тамхины хэрэглээ харилцан адилгүй байна. Тухайлбал Палестин улсад 47.7%,9 АНУ-д 36.6%,10 харин Австрали улсад харьцангуй доогуур буюу 9.4-11.7% үзүүлэлттэй тус тус гарсан.[11] Түүнчлэн эрчүүдэд тамхины хэрэглээний түвшин өндөр бөгөөд ихэнхдээ бага наснаасаа тамхи татаж эхэлсэн (74.4% нь ≤18 наснаас эхэлсэн) байгаа нь манай судалгааны үр дүнтэй нийцэж байгаа юм.

Залуучууд тамхи татах нь тэдгээрийн амьдарч буй орчинтой нягт холбоотой бөгөөд ихэнх тохиолдолд нийгэм, соёлын онцлогоор тодорхойлогддог. Нийгмийн хувьд зарим эрсдэлтэй зан үйл, тухайлбал тамхины хэрэглээ, архины хэрэглээ нь Бразилийн зүүн хойд бүсийн хөдөө орон нутагт бага насандаа эрэгтэйчүүд тамхинд ороход нөлөөлсөн бөгөөд бидний судалгааны үр дүнгээр мөн амьдрах болон ажиллах орчинд хэн нэгэн тамхи татдаг байх нь залуучууд тамхи хэрэглэхэд нөлөөлж байгаа гэж үзсэн.

Өөр нэгэн хүчин зүйлийг дурдвал, эцэг эхийн аль нэг нь тамхи хэрэглэдэг байх нь залуучууд тамхинд донтоход нөлөө үзүүлдэг бөгөөд үүнээс гадна хувь хүний эмзэг байдал, нийгмийн дарамт, тамхины хүртээмж зэрэг гурвал хүчин зүйл мөн адил нөлөөлж байдаг.[12] Үүнээс гадна, зарим судлаачид үе

тэнгийнхний тамхидалт залуу иргэдийг тамхи татахад хамгийн хүчтэй нөлөөлдөг гэж тэмдэглэжээ. Манай улсын хувьд тамхины хор уршгийн талаар мэдээлэлгүй байх, гэр орондоо идэвхигүй тамхидалтанд өртөх, зар сурталчилгаа болон бусдын ятгалганд орох зэрэг нь никотины донтолтод нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйл болж байгааг бидний судалгааны үр дүн харуулж байна.

Никотины хамааралт хүчин зүйлсийн хувьд нийт тамхи хэрэглэгсдийн 49.3% буюу дийлэнх хувийг бэхжсэн хэрэглэгч буюу өдөр тутамдаа тамхийг хэрэглэдэг, никотинд хамаарал өндөртэй хүмүүс эзэлж байгаа нь никотины донтуулах хувь энэ чинээгээр их байгааг батлаж байна. Электрон тамхи болон янжуур тамхины хамаарал үүсгэх нөлөөнд томоохон ялгаа байхгүй ч янжуур тамхи татдаг хүмүүс бэхжсэн хэрэглэгч, электрон тамхи татдаг хүмүүс завсрын хэрэглэгч болгох хандлага ажиглагдсан нь тамхинд агуулагдах никотины хэмжээтэй холбоотой байж болзошгүй. (Электрон тамхинд 0.5–15.4 мг; янжуур тамхинд 30.08–50.89 мг никотин тус тус агуулагдана.)[13]

Дүгнэлт: Улаанбаатар хотын залуучуудын 3 хүн тутмын 1 нь ямар нэгэн төрлийн тамхийг хэрэглэж байна. Тамхины хэрэглээг бууруулахад сургууль, байгууллагуудын иргэдийн дундах эрүүл мэндийн боловсролыг дэмжих болоод ямар ч төрлийн тамхины ил болон далд сурталчилгааг зогсоож, хяналт тавих шаардлагатай.

Ном зүй:

1. *Benowitz NL. Pharmacology of Nicotine: Addiction, Smoking-Induced Disease, and Therapeutics. Annu Rev Pharmacol Toxicol. 2009;49(1):57-71. doi:10.1146/annurev.pharmtox.48.113006.094742*
2. *The Ministry of Health. TOBACCO INDUSTRY INTERFERENCE INDEX.; 2021.*
3. *Chimed-Ochir O, Delgermaa V, Takahashi K, et al. Mongolia health situation: based on the Global Burden of Disease Study 2019. BMC Public Health. 2022;22(1):5. doi:10.1186/s12889-021-12070-3*
4. *Charan J, Biswas T. How to calculate sample size for different study designs in medical research? Indian J Psychol Med. 2013;35(2):121-126. doi:10.4103/0253-7176.116232*
5. *Naing L, Nordin RB, Abdul Rahman H, Naing YT. Sample size calculation for prevalence studies using Scalex and ScalaR calculators. BMC Med Res Methodol. 2022;22(1):209. doi:10.1186/s12874-022-01694-7*
6. *Public Health Institute, Ministry of Health (Mongolia), World Health Organization (WHO). Mongolia STEPS Noncommunicable Disease Risk Factors Survey 2019. Geneva, Switzerland: World Health Organization (WHO).*
7. *WHO global report on trends in prevalence of tobacco use 2000–2030. Accessed April 4, 2024. https://www.who.int/publications-detail-redirect/9789240088283*
8. *Tobacco use prevalence by age worldwide 2000-2030. Statista. Accessed April 4, 2024. https://www.statista.com/statistics/937317/tobacco-smoking-prevalence-globally-by-age/*
9. *Kelsh S, Ottney A, Young M, Kelly M, Larson R, Sohn M. Young Adults' Electronic Cigarette Use and Perceptions of Risk. Tob Use Insights. 2023;16:1179173X231161313. doi:10.1177/1179173X231161313*
10. *Health NC for CDP and HP (US) O on S and. Patterns of Tobacco Use Among U.S. Youth, Young Adults, and Adults. In: The Health Consequences of Smoking—50 Years of Progress: A Report of the Surgeon General. Centers for Disease Control and Prevention (US); 2014. Accessed April 4, 2024. https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK294302/*
11. *Australia T in. 1.4 Prevalence of smoking—young adults. Accessed April 4, 2024. https://www.tobaccoinaustralia.org.au/chapter-1-prevalence/1-4-prevalence-of-smoking-young-adults*
12. *Smoking Addiction and Risk Factors in Teenagers in Abidjan, Cote d'Ivoire. Accessed April 4, 2024. https://www.scirp.org/journal/paperinformation?paperid=88490*
13. *Nicotine - Public Health Consequences of E-Cigarettes - NCBI Bookshelf. Accessed April 4, 2024. https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK507191/14*

Evaluation of factors affecting smoke use and tobacco addiction among young citizens of Ulaanbaatar city

Khaliun S[1], Egshiglen B[1], Nomin-Erdene B[2], Altankhishig B[2], Maral N[2], Ekaterina F[2], Manduul Z[1], Dorjbalam G[3], Jargaltulga. U[1,3], Ryenchindorj E[3], Chimedsuren.O[4]

[1]School of Medicine, Mongolian National University of Medical Sciences
[2]School of Biomedicine, Mongolian National University of Medical Sciences
[3]Evidence-Based Medicine Research Institute of Mongolia
[4]Presidential office of Mongolia
E-mail:Jargaltulga.U@gmail.com, Tel:+976 85300909

Background: The increase in smoking among young people in the world in recent years is directly related to the increase in the production and consumption of smoky cigarettes, and within this, the cases of nicotine addiction are increasing drastically. Therefore, in this study, we aim to evaluate the degree of smoking addiction among young citizens of Ulaanbaatar and compare the factors that can affect it.

Aim: To evaluate the prevalence of tobacco use among young citizens of Ulaanbaatar and some factors that may influence their addiction. To determine the prevalence of tobacco use among young citizens of Ulaanbaatar.

Materials and Methods: From November 2023 to January 2024, a survey was conducted from 13 to 44 years of age in Ulaanbaatar, and the sample was collected randomly. “STEPS” and “GYTS”
were used in the questions. The general descriptive and Chi-square methods in the IBM-SPSS 26 program were used for processing the results, and statistically significant differences were evaluated at $p<0.05$.

Results: A total of 1362 people participated in the study, 59.5% (n=811) were women, 40.5% (n=551) were men. 18.8% of the respondents smoke cigarettes, 23.2% smoke electronic cigarettes, and the total consumption of tobacco was 34.9%. Compared to gender, tobacco use was higher among men, with a cigarette and total tobacco use highest among 25-44 year olds and e-cigarette use among 16-24 year olds. 43.1% of smokers have someone who smokes at home, and 72.9% have someone who smokes at work. 27.3% ($p<0.05$) of those who discussed the harmful effects of smoking in the last 1 year are smoking. However, the age at which smoking was first tried and the type of smoking was not related to smoking.

Conclusion: 1 out of 3 youths in Ulaanbaatar use some kind of tobacco. To reduce the consumption of tobacco, it is necessary to support health education among citizens in schools and institutions and to stop and monitor all kinds of open and hidden advertising of tobacco.

Keywords: *S*moking, addiction, nicotine dependence, youth health, substance use